



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/Нэ.

Аргатай

Сумын онцгой комиссын бүрэлдэхүүн
журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/б/, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 23.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг сумын нутаг дэвсгэрт удирдан зохион байгуулах үүрэг бүхий Онцгой комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Онцгой комиссын дарга: Сумын засаг даргын орлогч
Мэргэжлийн ангийн дарга :Засаг даргын тамгын газрын дарга
Гишүүд: Эрүүл мэндийн төвийн дарга
Мал эмнэлгийн тасгийн дарга
Улсын бүртгэгч
Санхүү албаны дарга
Сургуулийн захирал
Цэцэрлэгийн эрхлэгч
Соёлын төвийн эрхлэгч
Хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн
Байгаль орчны мэргэжилтэн
Газрын даамал
Цаг уурч
ХААТ-ын мэргэжилтэн
Төрийн сангийн мэргэжилтэн
Цагдаагийн хэсгийн төлөөлөгч
1 дүгээр багийн засаг дарга
2 дугаар багийн засаг дарга
3 дугаар багийн засаг даргап

2. Онцгой комиссын ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

3. Болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлж аврах, хор уршгийг ажлыг шуурхай удирдан зохион байгуулж ажиллахыг Онцгой комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/23 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай

ЗАСАГ ДАРГЫН ТҮР

ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЗОЛЗАЯА

